



186 Page



187 Page



188 Page



189 Page

Нааман жанжин

- General Naaman-

Тайлбарлагч Израильтай хөрш зэргэлдээ Арам улсад Нааман гэдэг нэртэй цэргийн жанжин амьдарч байлаа. Тэрээр улсдаа хүндлэгдсэн нэртэй сайн жанжин байв. Арамын хаан хүртэл Нааман жанжинд сайн ханддаг байлаа. Гэтэл, Нааман жанжин уяман өвчинтэй болжээ. Уяман өвчин гэдэг нь хүний биеийг мэдээгүй болгодог төдийгүй гар хөлийн хуруунууд, хөмсөг нь аажим аажмаар салан унасан ч юу мэдэрдэггүй аймшигтай өвчин байв.

Тайлбарлагч Нааман жанжны гэрт Израилиас боол болгон авчирсан нэгэн охин байлаа.

Охин Манай улсад Елиша гэгч эш үзүүлэгч бий. Тэр хүн уяман өвчнийг эдгээж чаддаг. Елиша, Бурханаас гуйн залбирахад л эдгэрэх болно.

Тайлбарлагч Бяцхан охин Бурханд итгэдэг байжээ.

Эхнэр “Тэр үнэхээр уяман өвчнийг эдгээж чадах уу?”

Охин “Тэгэлгүй яахав, эдгээж чадна.”

Тайлбарлагч Нааманы эхнэр нөхөртөө сонссон бүхнээ ярьжээ. Нааман жанжин үүнийг сонсоод :

Нааман “Үнэхээр тэр өвчинг эдгээж чадах юм бол хурдан явъя.”

Тайлбарлагч Ингээд Нааман жанжин Израиль уруу явжээ. Тэр Елишад өгөх бэлгээ хүртэл бэлдсэн байв. Тэд явсаар Израильд хүрч, Елишагийн байгаа газар иржээ. Гэтэл Елиша гарч ирсэнгүй. Харин зарц нь Елишагийн үгийг дамжуулав.

Зарц “Та Иордан голын усаар долоон удаа биеэ угаавал бие чинь цэвэрхэн болно.”

Нааман Чиний эзэн чинь хаана байгаа юм бэ? Их зантай хүн бэ? Арамын жанжин ирчихээд байхад, үл тоож зарцаа илгээлээ гэж үү. Манай улсын гол мөрөн Иорданы голоос ч илүү цэвэрхэн байхад яагаад заавал энэ голд угаа гэж байгаа юм бэ? Хурдан Арам уруугаа буцацгаая!

Тайлбарлагч Нааман жанжин маш их уурласан байлаа. Гэсэн ч зарц нь түүнд дахин хэлжээ.

Зарц “Жанжин минь, Иордан голд долоон удаа биеэ угаах нь амархан ажил шүү дээ. Энэ хүртэл ирсэн юм чинь хийгээд үзвэл дээр биш гэж үү?”

Тайлбарлагч Нааман жанжин зарцынхаа үгэнд орж, Иордан гол уруу явав. Нэг удаа, хоёр удаа, гурав, дөрөв...зургаа дахь удаагаа усанд булхсан ч бие нь эдгэрсэн шинж байхгүй байлаа.



190 Page



191 Page

Тэгээд долоо дахь удаагаа булхтал, гайхалтай зүйл болжээ. Жанжны бүх бие маш цэвэрхэн болж, эдгэрчээ. Шархалж, идээ гоожиж байсан бүх газар нь нялх хүүхдийн бие шиг дахин сэргэж, цэвэр болжээ.

.....

Нааман Үнэхээр гайхалтай!!

Хүмүүс “Үгүй нээрээ, ийм зүйл байдаг аа!!”

Тайлбарлагч Үүнээс хойш Нааман жанжин, Бурханд итгэх болжээ. Нааман жанжин Елишад үнэхээр их баярлажээ.

Нааман “Елиша, баярлалаа. Би одооноос эхлэн намайг эдгээж өгсөн Бурханд сайн итгэж, түүнд үйлчлэх болно. Бурханд заавал хүндлэл өргөж байх болно. Амлая”

Тайлбарлагч Нааман жанжин баяр хөөрөөр дүүрэн өөрийн нутаг уруугаа буцан явжээ.